



164

**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/106

Ховд

┌ **Үнэлгээний хороо байгуулах тухай** ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх “Үйлдвэр технологийн паркийн ерөнхий төлөвлөгөө, дэд бүтцийн зураг төсөл” /Ховд, Жаргалант сум/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Долгорсүрэн - Цаст-Алтай цогцолбор сургуулийн эмч

Б.Батзол - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Г.Галмандах - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн

дарга: Х.Дэмид

- Худалдан авах ажиллагаа ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо /Ц.Даваасамбуу/-нд даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Х.Дэмид/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

D/Tush-A/106-Bo

02 0953